



МОНГОЛЫН МЭС ЗАСАЛЧ ЭМЧ НАРЫН ХОЛБОО

ШИНЭЧИЛСЭН

2024 оны 02-р сарын 01-ны өдөр

№ 03/2024

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД

*“Мэс засал” мэргэшлийн зэргийн шалгалтын
“Тусгай” шалгуурыг хүргүүлэх нь*

Эрүүл мэндийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны А/513 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын дагуу ММЗЭНХ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн 2023 оны 01-р сарын 10-ны хурлаар зэргийн шалгалтын “Тусгай” шалгуурыг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

АХЛАХ зэрэг горилогч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. 2019 оны А/513 дуугаарын журмын 4.1.-ийн дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. Мэргэшлийн Ахлах зэрэг горилогч нь 8 жил мэс засалч мэргэжлээрээ ажилласан байна.
3. ММЗЭНХолбооноос зохион байгуулж буй дотоодын болон гадаадын багц цагийн сургалтанд 2 болон түүнээс олон удаа оролцож баталгаажуулсан байна.
4. Мэргэжлийн сэтгүүлд 5 болон түүнээс дээш тооны эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна.
5. Нийтлүүлсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай эрдэм шинжилгээний бүтээлийн 3 болон түүнээс дээш тооны өгүүлийг мэргэжлийн чиглэлийн “Мэс засал” сэтгүүлд заавал нийтлүүлсэн байна.
6. Нийт нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлийн 3 болон түүнээс дээшхид 1-р зохиогчоор оролцсон байна.
7. ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд мэргэжлийн чиглэлийн 2 болон түүнээс дээш тооны аман илтгэл, ханан илтгэл хэлбэрээр эрдэм шинжилгээний бүтээлээ танилцуулсан байна.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. 2019 оны А/513 дугаарын журмын 4.2.-ийн дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. “Мэс засал” мэргэшлийн Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил мэс засалч мэргэжлээрээ ажилласан байна.
3. Хэрэв горилогч нь Анагаах ухааны магистрын эрдмийн зэрэгтэй тохиолдолд, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэнтэй адилтган мэргэжлээрээ 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байна.
4. ММЗЭНХолбооноос зохион байгуулж буй дотоодын болон гадаадын багц цагийн сургалтанд 2 болон түүнээс олон удаа оролцож баталгаажуулсан байна.
5. Мэргэжлийн сэтгүүлд 15 болон түүнээс дээш тооны эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна.



МОНГОЛЫН МЭС ЗАСАЛЧ ЭМЧ НАРЫН ХОЛБОО

6. Нийтлүүлсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай эрдэм шинжилгээний бүтээлийн 10 болон түүнээс дээш тооны өгүүллийг мэргэжлийн чиглэлийн “Мэс засал” сэтгүүлд заавал нийтлүүлсэн байна.
7. Нийт нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн 10 болон түүнээс дээшхид 1-р зохиогчоор оролцсон байна.
8. ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд мэргэжлийн чиглэлийн 3 болон түүнээс дээш тооны аман илтгэл, ханан илтгэл хэлбэрээр эрдэм шинжилгээний бүтээлээ танилцуулсан байна.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. 2019 оны А/513 дугаарын журмын 4.3.-ийн дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. “Мэс засал” мэргэшлийн Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш 11 жил мэс засалч мэргэжлээрээ ажилласан байна.
3. Зөвлөх зэрэг горилогч нь АУ-ны докторын зэрэгтэй тохиолдолд, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэнтэй адилтган мэргэжлээрээ 22-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байна.
4. ММЗЭНХолбооноос зохион байгуулж буй дотоодын болон гадаадын багц цагийн сургалтанд 2 болон түүнээс олон удаа оролцож баталгаажуулсан байна.
5. Тус бүр 5 х.хуудаснаас багагүй 2 ширхэг ном товхимолыг хэвлүүлсэн байна.
6. Мэргэжлийн сэтгүүлд 35 болон түүнээс дээш тооны эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна.
7. Нийтлүүлсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай эрдэм шинжилгээний бүтээлийн 20 болон түүнээс дээш тооны өгүүллийг мэргэжлийн чиглэлийн “Мэс засал” сэтгүүлд заавал нийтлүүлсэн байна.
8. Нийт нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн 20 болон түүнээс дээшхид 1-р зохиогчоор оролцсон байна.
9. ОУ-ын эрдэм шинжилгээний хуралд мэргэжлийн чиглэлийн 5 болон түүнээс дээш тооны аман илтгэл, ханан илтгэл хэлбэрээр эрдэм шинжилгээний бүтээлээ танилцуулсан байна.
10. Мэс заслын чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт бичиг, заавар, удирдамж боловсруулах, батлуулахад 5 болон түүнээс олон удаа оролцсон байна.

Монголын мэс засалч эмч нарын холбоо нь Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллахад үргэлжид таатай байдаг бөгөөд манай холбооны Удирдах зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийг хүлээн авна уу.

Монголын Мэс Засалч эмч нарын
холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга



Б.Батсайхан